



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/102/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг , Сайншанд сум 2019 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 90077079 Цахим хаяг: Аудитор: Г.Энхтөр Утас: 96441690 Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар , Сайншанд сум , Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайвшанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 2019.02.26 № 1-6/201 танай _____ -ны № _____ -т	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.ЗАЯАСАЙХАН ТАНАА
---	--

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 6,427,718.91 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, 9,297,114.51 төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа боловч холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ зөрчил нь санхүүгийн тайлангийн толилуулга ба илчлэл үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын ЗДТГ-ын дарга Г.Заяасайхан-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 23-наас 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөвсгөл сумын ЗДТГ нь Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд оновчтой бодлого зохицуулалтаар хангах , төрийн болон тбрийн бус байгууллага , аж ахуйн нэгж , иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийг үйлчилгээг чанартай шуурхай хүргэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага , аж ахуйн нэгж , иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого холбогдох стандарт, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөвсгөл сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлдэг тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны Нийт зардал 437,937.3 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 1,513.57 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	12,120.70	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	400.80	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	12,521.50	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэгчээр баталгаажуулаагүй /гарын үсэггүй/ анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байхад шатахууныг зардалд тооцсон байна. Тухайлбал ДГО 48-88 2018 оны 4 дүгээр сарын 14-нд 70 л , ДГО 38-59 2018 оны 7 дугаар сарын 19-нд 10 л , 7 дугаар сарын 21-нд 45 л , 7 дугаар сарын 23-нд 30 л , ДГА 65-93 2018 оны 12 дугаар сарын 6-нд 65 л , ОМА 70-03 2018 оны 12 дугаар сарын 20-нд 20 л шатахуун тус тус зарлагадсан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 295,791.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 294,732.0 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь томилолт, бараа үйлчилгээний зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөвсгөл сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 6427718,91 төгрөгийн авлагын , 3903560 өглөгийн тус тус үлдэгдэлтэй боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй байна
2. Ахмадын сан байгуулсан боловч ямар нэг зарцуулалтын тайлангүй зардалд тооцсон , журамд сангаа хэрхэн бүртгэх , зарцуулагдаагүй үлдэгдлийг хэрхэн тайлагнах талаар тодорхой тусгаагүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 6427718,91 төгрөгийн авлагын , 3903560 өглөгийн тус тус үлдэгдэлтэй боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй байна

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 , 20.2.6 заалтуудыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Ахмадын сан байгуулсан боловч ямар нэг зарцуулалтын тайлангүй зардалд тооцсон , журамд сангаа хэрхэн бүртгэх , зарцуулагдаагүй үлдэгдлийг хэрхэн тайлагнах талаар тодорхой тусгаагүй байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоол тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль дүрэм журам зөрчигдсөн байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сан байгуулах журамд сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг хэрхэн бүртгэх талаар тодорхой тусгах нь зүйтэй

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

	Үзүүлт	ҮЛДЭГ ДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,307,948.13	35,631,947.00
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ	0.00	-
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	-
9	Төгрөг	0.00	-
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	-
27	АВЛАГА	1,911,000.00	6,427,718.91
34	Бусад авлага	1,911,000.00	6,427,718.91
35	Байгууллагаас авах авлага	1,911,000.00	6,427,718.91
60	БАРАА МАТЕРИАЛ	24,014,148.13	25,441,128.09
66	Хангамжийн материал	16,753,928.13	18,180,908.09
67	Бичиг хэргийн материал	788,830.00	757,750.00
68	Аж ахуйн материал	12,116,518.13	10,789,897.59
70	Түвш шатах тослох материал	1,973,580.00	2,336,260.50
71	Барилгын засварын материал	1,875,000.00	1,897,000.00
73	Бусад хангамжийн материал	-	2,400,000.00
75	Мал, амьтад	7,260,220.00	7,260,220.00
76	НӨӨЦИЙН БАРАА	7,382,800.00	3,763,100.00
79	Тэжээлийн нөөц	7,382,800.00	3,763,100.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,392,437,890.63	1,084,727,053.33
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,392,437,890.63	1,084,727,053.33
108	Биет хөрөнгө	1,392,168,099.00	995,103,011.72
109	Барилга, байгууламж	1,179,270,223.20	480,034,438.96
110	Хуримтлагдсан эзгэдэл	(316,391,640.04)	(16,336,825.55)
111	Авто тээврийн хэрэгсэл	159,703,800.00	143,793,800.00
112	Хуримтлагдсан эзгэдэл	(99,561,133.64)	(96,638,794.52)
113	Машин, тоног төхөөрөмж	152,383,389.08	148,812,029.08
114	Хуримтлагдсан эзгэдэл	(105,376,085.86)	(111,491,298.06)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,528,488.39	49,610,595.39
116	Хуримтлагдсан эзгэдэл	(21,852,356.97)	(22,971,834.24)
122	Бусад үндсэн хөрөнгө	783,080,412.40	856,921,432.60
123	Хуримтлагдсан эзгэдэл	(390,616,997.56)	(436,630,531.94)
126	Биет бус хөрөнгө	269,791.63	89,624,041.61
127	Програм хангамж	1,633,500.00	1,633,500.00
128	Хасагдуулга	(1,363,708.37)	(1,407,458.39)
129	Бусад биет бус хөрөнгө	-	89,398,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,425,745,838.76	1,120,359,000.33
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	3,903,560.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,903,560.00
164	Өглөг	-	3,903,560.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	2,248,406.00
170	Бусад өглөг	-	1,655,154.00
171	Байгууллагад төлөх өглөг	-	1,580,000.00
172	Хувь хүмүүст төлөх өглөг	-	75,154.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,425,745,838.76	1,116,455,440.33
215	Засгийн газрын хувь оролцоо	1,425,745,838.76	1,116,455,440.33
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	1,316,366,735.81	1,405,764,735.81
217	Өмч: -Төрийн өмч	1,316,366,735.81	1,405,764,735.81
223	Хуримтлагдсан үр дүн	(8,620,245.52)	(452,346,702.21)
224	Өмнөх үеийн үр дүн	(8,620,245.52)	(8,588,623.52)
225	Тайланг үеийн үр дүн	-	(43,758,078.69)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,999,348.47	163,037,406.73
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,425,745,838.76	1,120,359,000.33

4417144353
E:CA0056 902570

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮҮҮҮЛАЛТ	ГҮҮЦЭГТЭЛ	ГҮҮЦЭМТЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	402,032,295.86	331,202,407.05
76	ҮАТВАРЫН БУС ОРЛОГО	126,119,942.86	41,546,149.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	126,119,942.86	33,296,149.00
82	Үндэсн үйл ажиллагааны орлогоос санхүүжсэн	126,119,942.86	33,296,149.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжсэн	319,797.00	384,390.00
84	Урьд таны үлдээлтээс санхүүжсэн	7,606,510.00	-
85	Үнэ төлбөргүй хууль ёсны орлого	2,292,446.06	-
99	Тусламжийн орлого	113,904,189.80	22,909,000.00
100	Хөндлөн тусламж (дотгодог)	-	8,250,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	8,250,000.00
121	Оны эхний үлдэгдлээс санхүүжсэн	271,813,480.00	279,656,238.05
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,053.00	-
126	Дотоод нэгж төсвийн захирагчид төсөвт тусгагдсан төсвийн доод нэгж төсвийн зэм	17,573,500.00	25,784,448.05
129	Орон нутгийн төсвийн санхүүжүүлэлт	17,573,500.00	25,784,448.05
130	Урьдны үйл ажиллагааны санхүүжүүлэлт (орон нутгийн төсөвт байгууллага)	258,239,900.00	253,871,810.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛЫН ДҮН (II)	238,239,900.00	253,871,810.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	299,566,104.16	446,111,300.00
149	ВАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,566,104.16	366,586,300.08
150	Цалин, хэсэг болон нэмэгдэл урамшаа	391,279,762.18	566,538,474.08
151	Цалин	192,770,623.00	198,052,230.83
157	Ажил олгогчоос нийгэмийн даатгал төлөх зориулалттай	22,599,912.55	17,505,469.45
158	Гэтгэмжийн даатгалын нэмэгдэл	14,548,813.00	12,731,006.00
159	Гэтгэмжийн даатгалын нэмэгдэл	2,003,960.00	1,129,117.00
160	УОМШ өмчийн даатгалын нэмэгдэл	1,648,942.00	1,029,461.00
161	Ажлаачид өмчийн даатгалын нэмэгдэл	296,771.00	266,380.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,001,426.55	2,289,505.45
164	Байр ашиглалттай зориулалттай тогтмол зардал	9,433,300.00	5,345,849.05
165	Газрын ашиглалтын зардал	2,819,900.00	3,279,699.05
166	Тусгай, хэргийн зардал	6,215,300.00	1,541,050.00
167	Цэвэр, бохир усны зардал	418,000.00	425,100.00
170	Хөдөлмөр, барилга материал зардал	36,317,018.91	46,781,470.43
171	Бичиг хэргийн материал	3,793,627.00	3,302,505.00
172	Тусгай, хэргийн зардал	13,826,612.91	8,464,183.00
173	Шүүхийн холбоо интернетын төлбөр	8,098,047.00	8,239,351.00
174	Нэм, хэргийн зардал	75,600.00	-
175	Хөгжлийн үйлчилгээ, төлбөр	210,000.00	182,200.00
176	Бага үнэ түргэл зориулалттай зардал	10,312,528.00	26,193,231.43
181	Норматив зардал	229,530.00	362,600.00
183	Хоол	-	360,200.00
184	Нормын хувиар, зөвлөх хэдэн	229,530.00	2,200.00
185	Эн хөдөлмөр, үргэлж засварын зардал	5,068,300.00	2,902,741.00
186	Бичиг хэргийн зардал	-	750,000.00
187	Тамга	-	500,000.00
189	Урсгал зардал	-	500,000.00
190	Тамга, зардал	5,068,300.00	1,652,741.00
192	Дотоод төмөрлөгийн зардал	4,948,800.00	3,812,700.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн өмч, үйлчилгээний төлбөр хураамж	9,196,220.00	12,148,765.30
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад өмчлөл ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,700,210.00	10,161,777.30
196	Аудит, баталгаажуулалт зэрэгт төлөх зардал	171,000.00	240,000.00
197	Давтгалын үйлчилгээний төлбөр	214,000.00	817,000.00
198	Газарын хэрэгсэлийн татвар	86,010.00	327,000.00
199	Газарын хэрэгсэлийн өнцөгчлөг	25,000.00	72,800.00
201	Газрын төлбөр	-	330,188.00
209	Барил үйлчилгээний бусад зардал	110,696,161.70	79,626,888.02
210	Барил үйлчилгээний бусад зардал	18,481,691.21	12,859,472.00
212	Үндэсн хөрөнгийн хөндлөн зардал	92,214,470.49	66,767,186.02
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭЛТ	8,286,342.00	47,826.00
228	Бусад урсгал шилжүүлэлт	8,175,000.00	47,826.00
229	Нийгмийн даатгалын зээт зөвхөр, тэтгэмж	-	47,826.00
236	Нэг удамгийн зээт зөвхөр, тэтгэмж	8,175,000.00	-
242	Орон нутгийн төсвийн прохойлоо захирагчид өгөх татвар, санхүүжүүлэлт	111,342.00	-
243	Төвлөрүүлэн шилжүүлэлт	111,342.00	-
253	ХӨРӨНГ ҮЙЛ ЗАРДАЛ	-	-
254	Дотоод зөвхөр	-	79,525,000.01
258	Бусад хөрөнгө	-	79,525,000.01
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-IV)	2,456,291.30	(124,928,803.04)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛЫН ДҮН (V)	1,111,111.04	318,849,185.65
277	Үндэсн хөрөнгө худалданы татвар	1,111,111.04	3,824,300.30
283	Хөрөнгө өнө дооно үйлчилгээний зардал	-	34,181,781.35
284	Дамжуулах зориулалттай зээл	-	842,094.12
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-VI.V)	1,348,490.66	(37,889,085.65)
288	НӨЙТ ҮР ДҮН (VII-III-VI)	-	(441,738,786.60)

4417144353
 ӨН0А0056 902570

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн *	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,316,366,735.81	104,428,793.96	(11,176,925.28)	1,409,618,604.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,292,446.06	2,292,446.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,316,366,735.81	104,428,793.96	(8,884,479.22)	1,411,911,050.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайланг үеийн үр дүн			1,345,180.66	1,345,180.66
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,316,366,735.81	117,999,348.47	(8,620,245.52)	1,425,745,838.76
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,316,366,735.81	117,999,348.47	(8,620,245.52)	1,425,745,838.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			31,622.00	31,622.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,316,366,735.81	117,999,348.47	(8,588,623.52)	1,425,777,460.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		45,038,058.26		45,038,058.26
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайланг үеийн үр дүн	89,398,000.00		(443,758,078.69)	(354,360,078.69)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(452,346,702.21)	1,116,455,440.33



АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	254,146,000.00	253,613,545.88	532,454.12	99.79
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	254,146,000.00	253,613,545.88	532,454.12	99.79
4	Бараа, үйлчилгээний зардал	254,146,000.00	253,613,545.88	*532,454.12	99.79
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,637,900.00	189,620,903.28	16,996.72	99.99
6	Үндсэн цалин	182,937,900.00	182,937,899.28	0.72	100.00
9	Урамшуулал	6,700,000.00	6,683,004.00	16,996.00	99.75
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,756,500.00	22,756,500.00	-	100.00
12	Тэтгэврийн даатгал	15,171,000.00	15,171,000.00	-	100.00
13	Тэтгэмжийн даатгал	1,896,400.00	1,896,400.00	-	100.00
14	ҮОМШӨ ний даатгал	1,517,100.00	1,517,100.00	-	100.00
15	Ажилгүйдлийн даатгал	379,300.00	379,300.00	-	100.00
16	Эрүүд мэндийн даатгал	3,792,700.00	3,792,700.00	-	100.00
17	Байр шингэлэлтэй холбоотой тогтмол зардал	7,657,400.00	7,657,400.00	-	100.00
18	Гэрэл цахилгаан	2,870,900.00	2,870,900.00	-	100.00
19	Тули, хялвалт	4,361,500.00	4,361,500.00	-	100.00
20	Цэвэр, бохир ус	425,000.00	425,000.00	-	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	14,869,400.00	14,868,555.60	844.40	99.99
23	Бичиг хэрэг	2,417,500.00	2,417,472.60	27.40	100.00
24	Тээвэр (шатахуун)	11,499,900.00	11,499,812.00	88.00	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	332,000.00	331,271.00	729.00	99.78
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	220,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00	-	100.00
30	Нормативт зардал	500,000.00	500,000.00	-	100.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	-	100.00
34	Эд хогшил худалдан авах	4,031,500.00	4,031,500.00	-	100.00
38	Урсгал засвар	4,031,500.00	4,031,500.00	-	100.00
39	Томилголт, зочны зардал	4,228,800.00	3,812,700.00	416,100.00	90.16
41	Дотоод албан томилголт	4,228,800.00	3,812,700.00	416,100.00	90.16
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10,464,500.00	10,365,987.00	98,513.00	99.06
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,419,000.00	8,384,799.00	34,201.00	99.59
45	Аудит, баталгажуулалт зэрэгтэй тогтоох зардал	240,000.00	240,000.00	-	100.00
46	Даатгалын үйлчилгээ	820,000.00	817,000.00	3,000.00	99.63
47	Тээврийн хэрэгсэлийн татвар	327,000.00	327,000.00	-	100.00
48	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	71,000.00	67,000.00	4,000.00	94.37
50	Газрын төлбөр	587,500.00	530,188.00	57,312.00	90.24
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	254,146,000.00	254,396,999.00	(250,999.00)	100.10
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	253,646,000.00	253,812,409.00	(166,409.00)	100.07
104	Орон нутгийн төсвөөс	253,646,000.00	253,812,409.00	(166,409.00)	100.07
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	584,590.00	(84,590.00)	116.92
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	584,590.00	(84,590.00)	116.92
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-	100.00
134	Улирдах ажилтан	7	7	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	10	9	1	90.00
136	Үйлчлэх ажилтан	8	9	(1)	112.50
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГЧЭДИЙН ТОО	-	-	-	-

4417144353
E:OAO058.9025707

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,645,772.05	41,118,486.05	527,286.00	98.73
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	41,645,772.05	41,118,486.05	527,286.00	98.73
4	Бараа, үйлчилгээний зардал	40,145,772.05	39,618,486.05	527,286.00	98.69
5	Цалин хале болон нэмэгдэл урамшил	310,000.00	310,000.00	-	100.00
9	Урамшуулал	310,000.00	310,000.00	-	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	14,906,903.00	14,740,803.00	166,100.00	98.89
23	Бичиг хэрэг	148,400.00	148,400.00	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	6,449,503.00	6,283,403.00	166,100.00	97.42
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,009,000.00	8,009,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, гургэн зээгдэх, аж ахуйн эд туйлс	300,000.00	300,000.00	-	100.00
30	Норматив зардал	923,370.00	923,360.00	10.00	100.00
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	23,500.00	23,500.00	-	100.00
32	Хоол, хүнс	899,870.00	899,860.00	10.00	100.00
34	Эд хогшил худалдан авах	5,988,000.00	5,988,000.00	-	100.00
36	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
38	Урсгал засвар	988,000.00	988,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,009,000.00	4,009,000.00	-	100.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,009,000.00	4,009,000.00	-	100.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	14,008,499.05	13,647,323.05	361,176.00	97.42
54	Бараа үйлчилгээний бусад зардал	14,008,499.05	13,647,323.05	361,176.00	97.42
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
72	Нийгмийн ааламгийн тэтгэвэр, тэтгэмж	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
73	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,873,132.00	41,118,486.05	1,754,645.95	95.91
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,131,864.00	(7,131,864.00)	-
115	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	8,250,000.00	(8,250,000.00)	-
116	Хандив тусламж /дотоод/	-	8,250,000.00	(8,250,000.00)	-
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,873,132.00	25,736,622.05	17,136,509.95	60.03
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төс	32,345,622.00	25,736,622.05	6,608,999.95	79.57
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	10,527,510.00	-	10,527,510.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-	100.00
134	Удирдах ажилтан	7	7	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	10	9	-	90.00
136	Үйлчлэх ажилтан	8	9	(1)	112.50
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жогийн дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4417144355
ЕЮА0056 9025707